

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Арвайхээр
2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Б.Авидцэрэн

Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын дүгнэлт



ОБОРХОНГОЙ АНГААГ ТАМЬ
ТОРШИНГ АУДИТЫН ГАЗАР

Утас: 7711-07100, 7711-07101
Төв, Төв, 15101
E-mail: oworking@audit.gov.mn

Хугацаа: 2022.07.10 №: 103
Хугацаа: _____ №: _____

ХАРХОРИНЫ НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ЭМЧ Д.ЭНХЗАЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




О.БАТЖАРГАЛ

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	182,111,954.82	914,390,202.27
33	АВЛАГА	45,192,292.00	559,652,964.18
33300	Татаас, санхүүжилтийн авлага	32,133,813.00	553,076,382.20
335	Бусад авлага	13,058,479.00	6,576,581.98
3351	Байгууллагаас авах авлага	13,058,479.00	6,576,581.98
35	БАРАА МАТЕРИАЛ	136,919,662.82	354,737,238.09
351	Түүхий эд материал	97,002,120.12	292,520,310.99
35110	Тусгай зориулалттай материал	63,311,325.86	118,183,652.39
35130	Эм боох материал	33,690,794.26	174,336,658.60
354	Хангамжийн материал	39,917,542.70	62,216,927.10
35410	Бичиг хэргийн материал	153,000.00	82,800.00
35420	Аж ахуйн материал	544,665.60	1,307,360.00
35460	Хүнсний материал	178,200.00	538,880.00
35470	Бусад хангамжийн материал	39,041,677.10	60,287,887.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,192,234,322.44	2,608,750,225.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,192,234,322.44	2,608,750,225.01
392	Биет хөрөнгө	1,925,927,668.35	2,342,512,320.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,137,852,979.67	1,137,852,979.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,288,478.48)	(54,286,543.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	263,327,759.00	263,327,759.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(108,099,477.830)	(156,512,823.870)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,332,252,951.83	1,944,681,775.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(711,989,764.95)	(848,038,462.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,621,671.96	65,858,971.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,620,919.87)	(19,798,378.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,414,264.44	24,414,264.44
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,543,317.42)	(14,987,220.90)
393	Биет бус хөрөнгө	266,306,654.09	266,237,904.05
39301	Програм хангамж	6,571,711.40	6,571,711.40
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,229,057.310)	(5,297,807.350)
39303	Бусад биет бус хөрөнгө	264,964,000.00	264,964,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,374,346,277.26	3,523,140,427.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,133,813.00	523,247,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,133,813.00	523,247,500.00
413	Өглөг	32,133,813.00	523,247,500.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	29,824,613.00	489,655,793.00
4136	Бусад өглөг	2,309,200.00	33,591,707.00
41361	Байгууллагад төлөх өглөг	809,200.00	24,737,607.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,500,000.00	8,854,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,342,212,464.26	2,999,892,926.40
51	Засгийн газрын хувь оролцоо	2,342,212,464.26	2,999,892,926.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон	1,043,592,295.39	1,043,592,295.39
51101	Өмч: - төрийн	1,043,592,295.39	1,043,592,295.39
512	Хуримтлагдсан үр дүн	474,427,112.48	1,132,107,575.50
51210	Өмнөх үеийн үр дүн	474,427,112.48	474,427,112.48
51220	Тайлант үеийн үр дүн	-	657,680,463.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	824,193,056.39	824,193,056.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,374,346,277.26	3,523,140,427.28

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,361,325,489.00	5,394,437,335.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,991,470.00	1,504,634,282.34
120	Нийтлэг татварын бус орлого	8,991,470.00	1,504,634,282.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,812,370.00	6,572,281.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,812,370.00	6,572,281.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,352,334,019.00	3,889,803,053.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	861,394,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	861,394,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,015,950.00	330,574,604.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,015,950.00	9,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	177,149,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	83,625,504.00
1330	Төсвийн захирагчдаас	-	200,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	200,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	489,923,369.00	3,359,228,449.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	489,923,369.00	3,359,228,449.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,408,963,428.39	4,736,310,929.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,408,963,428.39	4,736,310,929.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,408,163,428.39	4,582,010,929.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	827,484,846.00	2,124,574,171.19
210101	Үндсэн цалин	827,484,846.00	1,117,768,732.19
210102	Нэмэгдэл	-	875,688,859.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	63,117,000.00
210104	Урамшуулал	-	67,999,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,033,475.00	269,059,856.83
210201	Тэтгэврийн даатгал	72,124,801.00	205,104,121.62
210202	Тэтгэмжийн даатгал	8,314,796.00	16,873,682.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,608,155.00	13,246,945.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,450,188.00	3,044,194.47
210205	Эрүүл мэндийн даатгал	14,535,535.00	30,790,912.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,116,220.00	224,059,906.00
210301	Гэрэл, цахилгаан	-	31,695,417.00
210302	Түлш, халаалт	-	119,988,059.00
210303	Цэвэр, бохир ус	28,116,220.00	72,376,430.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,017,004.75	101,157,939.60
210401	Бичиг хэрэг	3,551,650.00	10,874,350.00
210402	Тээвэр, шатахуун	17,402,404.00	59,273,624.00
210403	Цуудан, холбоо, интернэтийн төлбөр	505,098.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,809,832.00	22,114,565.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,967,200.00	8,895,400.00
210408	Бараа материал акталсны зардал	1,780,820.75	-
2105	Нормативт зардал	263,424,365.38	1,269,881,189.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	225,030,000.38	1,136,665,594.46
210502	Хоол, хүнс	37,942,365.00	131,901,095.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	452,000.00	1,314,500.00

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,949,910.00	59,532,238.23
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,032,758.23
210604	Урсгал засвар	3,949,910.00	49,499,480.00
2107	Томилолт, зочны зардал	1,862,000.00	6,286,100.00
210702	Дотоод албан томилолт	1,862,000.00	6,286,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,755,660.00	3,649,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,186,900.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,200,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,860.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,992,700.00	3,649,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	85,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,519,947.26	523,810,528.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	211,075,632.18
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	139,519,947.26	312,734,896.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	154,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	154,300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	154,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	300,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(47,637,939.39)	658,126,405.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	445,942.35
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	445,942.35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(445,942.35)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(47,637,939.39)	657,680,463.02

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,043,592,295.39	824,193,056.39	366,226,200.15	2,234,011,551.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,043,592,295.39	824,193,056.39	366,226,200.15	2,234,011,551.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	-
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-37,842,171.94	(37,842,171.94)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,043,592,295.39	824,193,056.39	474,427,112.48	2,342,212,464.26
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,043,592,295.39	824,193,056.39	474,427,112.48	2,342,212,464.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,043,592,295.39	824,193,056.39	474,427,112.48	2,342,212,464.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	657,680,463.02	657,680,463.02
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,043,592,295.39	824,193,056.39	1,132,107,575.50	2,999,892,927.28

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,864,313,102.00	3,898,680,264.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,434,009.00	6,572,281.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,434,009.00	6,572,281.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,434,009.00	6,572,281.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,434,009.00	6,572,281.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,851,879,093.00	3,892,107,983.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,860,037,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,860,037,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,932,382.00	330,574,604.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,614,862.00	9,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	60,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,391,520.00	177,149,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,926,000.00	83,625,504.00
1330	Төсвийн захирагчдаас	-	200,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	200,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	973,909,311.00	3,361,533,379.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	973,909,311.00	3,329,399,566.80
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	32,133,813.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,833,805,977.00	3,861,102,264.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,833,805,977.00	3,861,102,264.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,799,652,164.00	3,707,102,264.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,733,315,200.00	2,109,200,600.00
210101	Үндсэн цалин	939,677,429.00	1,057,558,875.00
210102	Нэмэгдэл	587,638,476.00	867,374,430.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,555,140.00	70,192,533.03
210104	Урамшуулал	134,444,155.00	114,074,761.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,622,500.00	289,103,527.00
210201	Тэтгэврийн даатгал	161,706,788.23	205,989,127.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,412,695.45	20,778,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,920,116.32	14,822,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,416,600.00	5,955,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,166,300.00	41,557,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,974,700.00	-
210301	Гэрэл, цахилгаан	27,926,743.00	-
210302	Түлш, халаалт	121,494,217.00	-
210303	Цэвэр, бохир ус	43,553,740.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	61,909,095.00	-
210401	Бичиг хэрэг	6,010,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	31,592,420.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,274,798.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,661,527.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,369,850.00	-
2105	Нормативт зардал	532,599,151.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	441,801,441.00	-
210502	Хоол, хүнс	78,963,710.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,834,000.00	-

**Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,294,018.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,920,245.00	-
210604	Урсгал засвар	17,373,773.00	-
2107	Томилолт, зочны зардал	5,703,900.00	-
210702	Дотоод албан томилолт	5,703,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,233,600.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,186,900.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,846,500.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	333,300.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,122,700.00	-
210807	Газрын төлбөр	412,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	802,200.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,420,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,308,798,137.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,308,798,137.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,153,813.00	154,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,020,000.00	154,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	154,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,020,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,133,813.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,133,813.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,507,125.00	37,578,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,507,125.00	37,578,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,507,125.00	37,578,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,507,125.00	37,578,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,507,125.00	37,578,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(30,507,125.00)	(37,578,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,642,805,769.80	3,542,805,769.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,642,805,769.80	3,542,805,769.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,642,805,769.80	3,542,805,769.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,077,857,600.00	2,077,857,600.00
210101	Үндсэн цалин	979,072,500.00	1,026,215,875.00
210102	Нэмэгдэл	875,694,300.00	867,374,430.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,230,000.00	70,192,533.03
210104	Урамшуулал	146,860,800.00	114,074,761.81
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	287,834,527.00	287,834,527.00
210201	Тэтгэврийн даатгал	204,720,127.00	204,720,127.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,778,600.00	20,778,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,822,900.00	14,822,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,955,700.00	5,955,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,557,200.00	41,557,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,277,113,642.80	1,177,113,642.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,277,113,642.80	1,177,113,642.80
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,642,805,769.80	3,542,805,769.80
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,636,233,488.80	3,536,233,488.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,636,233,488.80	3,504,099,675.80
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	0.00	32,133,813.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6572281	6572281
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,572,281.00	6,572,281.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	90.00	113.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	64.00	83.00
620003	Үйлчлэх ажилтан	25.00	29.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		285,636,795.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		285,636,795.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		131,636,795.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		31,343,000.00
210101	Үндсэн цалин		31,343,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,269,000.00
210201	Тэтгэврийн даатгал		1,269,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	99,024,795.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		154,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		154,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	210,336,904.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		210,336,904.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан		
131101	хандив, тусламж		9,000,000.00
	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй		
131103	нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,800,000.00
	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан		
131104	төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		177,149,100.00
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны		
131105	хүрээнд бий болсон нэмэлт орлого		13,387,804.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хархорины нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хархорины нэгдсэн эмнэлэг нь үйлчлэх хүрээний хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэн, хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт орж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих болсон ба байгууллагын бусад үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч 2011 онд батлагдсан тул зарим өөрчлөлтийг хийж шинэчлэх шаардлагатай болсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн гаргасан "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг ерөнхий эмчийн 2020 оны А/09 тоот тушаалын хавсралтаар баталсан, 2021 оны ажлын төлөвлөгөө гаргасан боловч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорины нэгдсэн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3058.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 30.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 21.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 452.9 сая төгрөгөөр өссөн байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтаар 734,7 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж хүлээн авсан, ашиглах хугацаа дууссан хөрөнгөд дахин үнэлгээ хийсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 215.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эм, тусгай зориулалтын материал хөрөнгө оруулалтаар огцом өссөнөөс шалтгаалжээ.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 халдварын эмчилгээний зардлын санхүүжилтээс 553.1 сая төгрөг олгоогүй он дамжуулснаар энэ хэмжээний авлага үүсгэсэн байна.
- Дээрх авлагаас барагдуулах урсгал, тогтмол зардлын, эмийн, нийт 523.2 сая төгрөгийн өглөг тайлагнажээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Эрүүл мэндийн газарт нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 3,222.6 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 3034.0 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсөв 3034.0 сая төгрөгөөр батлагдаж, эрүүл мэндийн даатгалаас 3,536.2 сая төгрөгийн санхүүжилт авсан. Үндсэн үйл ажиллагааны орлогоор 6.6 сая төгрөгийн орлого оруулж, нийт төсвийн гүйцэтгэл 3,542.8 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилт тайлант онд 330.6 сая төгрөг, тухайлбал:

- Байгууллага, хувь хүмүүсээс мөнгөн дүнгээр хүлээн авсан хандив 9.0 сая,
- Засаг даргын нөөцөөс зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилт 10.8 сая,
- дээд байгууллага болох ЭМЯ-наас 177.1 сая,
- байгууллагын өөрийн орлого 83.6 сая төгрөг тус тус орж, 70.2 сая төгрөгийг кассаас бэлнээр, бусдыг нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Байгууллагын төсөв захирагчийн шийдвэрээр олгосон цалингийн нэмэгдэл, урамшуулалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх цаг хугацааны боломж гараагүй болохыг онцолж байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн. Үүнд:

- Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А/12 тоот тушаалын 3 дугаар заалтаар тодорхойлсон зардлын зүйлийг зөрчиж, коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээний төлбөрийн 11.8 сая төгрөгийн орлогыг зориулалт бусаар зарцуулсан.
- Шинжилгээний төлбөрийн 70.2 сая төгрөгийн орлогыг кассаар хураан авсан боловч байгууллагын төрийн сан дахь дансанд төвлөрүүлээгүй. Төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж эхэлсэн боловч төрийн сангийн дансанд мөнгө тушаахад заавал банканд очиж гүйлгээ хийлгэдэг, эрх нээлгэж зарцуулах явц нь хугацаа алдаж, тухайн үеийн эмнэлгийн байгууллагын нөхцөл байдалтай зохицохгүй байсан талаар бичгээр тайлбар гаргаж өгснийг Тэргүүлэх аудиторт танилцуулсан.
- Нэг удаагийн бус шинж чанартай 2.4 сая төгрөгийн бараа материалыг зардалд бичиж данснаас хассан.
- Үйлчлүүлэгчдээс бэлнээр хүлээн авч хөрөнгө худалдан авсан 70.2 сая төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээнд тусгахгүйгээр хөрөнгийн орлогоор бүртгэсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнг энэ тайлангийн 5 дугаар зүйлд нэгтгэн тэмдэглэв.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хархорины нэгдсэн эмнэлэг нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон эрх бүхий сайд нарын тушаал зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг онцолсон асуудлаас бусад нь холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 албан шаардлага өгсөн нь биелсэн, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

- 2021 онд цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор эмнэлгийн байгууллагын цалин, урамшууллын талаар нэг удаагийн шинж чанартай шийдвэрүүд олон удаа гарсан, тэдгээрийн зарим нь 2022 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа тул цалин, урамшууллын зардлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

- Тус байгууллага нь төлбөртэй үйлчилгээний орлогыг журам заавраас гадуур, кассаар хүлээн авч зарцуулах хандлага ажиглагдсаныг анхаарч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 154.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 72.6 сая төгрөгийн алдааг залруулж, 11.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 70.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа:

Нийт 72.6 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Зардалд бичиж данснаас хассан 2.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн бичилтэд залруулга хийлгэж, бараа материалын дансны үлдэгдэлд бүртгүүлсэн.

- Үйлчлүүлэгчдээс бэлнээр хүлээн авч хөрөнгө худалдан авсан 70.2 сая төгрөгийн орлогыг өөрийн орлогод бүртгүүлж залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт:

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага:

- Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А/12 тоот тушаалын 3 дугаар заалтыг мөрдөж, коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээний төлбөрийн орлогыг тушаалд заасан зориулалтаар зарцуулж байх

4.4 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын өөрийн орлого бүрдүүлэлтийн асуудал:

1.1. Илрүүлэлт:

Шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэхгүй, кассаар хураан авч зарцуулсан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалт, Монгол улсын шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А/12 тоот тушаалын 3 дугаар заалтыг мөрдөж, шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хархорины нэгдсэн эмнэлэг	4	154.6	2	72.6	0	0	1	11.8	1	70.2

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Б.АВИДЦЭРЭН



